ART in Embassies Exhibition

United States Embassy Ulaanbaatar

MONGOLIA

COVER

Joseph K. Dixon, **Ari-Wa-Kis, Young Bull or Captin Jim, Pawnee Tribe**
Archival pigment copy print from original photograph, 1913. 50 x 34 in.
Courtesy of the William Hammond Mathers Museum, Indiana University, Bloomington, and the ART in Embassies Program, Washington, D.C.

Жозеф К. Диксон, **Ari-Wa-Kis, Young Bull or Captin Jim, Pawnee Tribe**
Эх зургаас татсан архивын хувь, 1913. 127 x 86,4 см
Блумингтон дахь Индиана их сургуулийн Уильям Хэммонд Матерс музей болон «Элчин сайдын яамд дахь Уран зураг» хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр толилуулж буй

Welcome to the United States Ambassador's Residence in Ulaanbaatar. The exhibition in the Residence's public area, curated by the ART in Embassies Program of the Department of State, honors Native Americans – the first peoples to inhabit the territory comprising our country. I hope you enjoy viewing these works of art as much as I enjoyed selecting them.

The First Americans

The largest component of the exhibition, prints from century-old photographs taken by Joseph K. Dixon from originals in the collection of the William Hammond Mathers Museum (Indiana University, Bloomington), are portraits of Native Americans who lived on the Great Plains and in the Southwest – a landscape that reminds one of Mongolia. Indeed, these Native Americans – from the Crow, Pawnee, Yuma, Hopi, Navajo, and Apache Tribes – are believed to be related, culturally and ethnically, to the peoples of inner Asia, including Mongolia.

As well as being grateful to the Mathers Museum for their substantial loan, I also am indebted to Alice N. Rogoff, Chairwoman of the Alaska Native Arts Foundation of Bethesda, Maryland, for lending two masks from her collection of Alaskan Native American art. Created by the contemporary artists Susie Qimmiqsaq Bevins and Larry "Ulaaq" Ahvakana, these beautiful works are examples of the ever-vibrant artistic traditions of Native Americans.

In a larger sense, these works also inspire all who view them to reflect on how their own traditions and their contemporary lives can meet in artwork. Such art reminds us of where we come from and who we are, and conveys that sense to others as well. And it enriches our appreciation of the diversity and beauty of mankind's collective cultural heritage.

Mark C. Minton
Ambassador

Ulaanbaatar
April 2007

Улаанбаатарт суугаа АНУ-ын Элчин сайдын өргөөнд тавтай морилно уу. Тус өргөөний олон нийтэд нээлттэй хэсэгт тавигдсан үзэсгэлэнг Төрийн департаментын «Элчин сайдын яамд дахь уран зураг» хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр толилуулж буй бөгөөд уг үзэсгэлэн манай эх орны нутаг дэвсгэрт хамгийн анхлан суурьшсан хүмүүс болох уугуул Америкчуудад хүндэтгэл үзүүлж байгаа юм. Би эдгээр бүтээлүүдийг сонгож байхдаа эдэлсэн шиг тийм таашаалыг та бүхэн энэ бүтээлүүдийг хараад мэдэрнэ гэдэгт би итгэж байна.

Анхны Америкчууд

Энэхүү үзэсгэлэнгийн хамгийн том бүрэлдхүүн хэсэг бол зуу гаруй жилийн өмнө Жозеф К. Диксоны хальснаа бууж, одоо Блүмингтон дахь Индиана их сургуулийн Уильям Хэммонд Матэрсийн музейд эх нь хадгалагдаж буй гэрэл зургуудаас татаж авсан хуулбарууд юм. Эдгээр нь Монголын байгалтай их төстэй Их тал болон баруун өмнөд нутгаар амьдарч байсан уугуул Америкчуудын хөрөг зургууд юм. Үнэндээ Кроу, Пооний, Юума, Хопи, Навахо, Апачи зэрэг омгуудыг төлөөлөх энэ уугуул Америкчууд бол Төв Азийнхан, түүний дотор Монголчуудтай угсаа, соёлын хувьд холбоотой гэж яригддаг.

Уг бүтээлүүдийг энд үзүүлэхээр зээлдүүлсэн Матэрсийн музейд талархлаа илэрхийлэхийн зэрэгцээ Аляскийн уугуул Америкчуудын уран бүтээлийн цуглуулгаасаа хоёр ширхэг баг зээлдүүлсэн Мэрилэнд мужийн Бетезда дахь Аляскийн уугуул иргэдийн урлагийн сангийн дарга Элис Н. Рогофын өгөөмөр сэтгэлд талархаж байна. Сьюзи Кимиксак Бевинз, Ларри «Улаак» Авакана зэрэг орчин үеийн уран бүтээлчдийн гараар бүтсэн энэхүү үзэсгэлэн төгөлдөр бүтээлүүд нь уугуул Америкчуудын урлаг соёлын уламжлал амьд хэвээр байгаагийн тод жишээ болж байна.

Өргөн утгаар нь авч үзвэл, эдгээр бүтээлүүд аливаа ард түмний уламжлал соёл болон орчин үеийн амьдрал нь уран бүтээлд хэрхэн сүлэлдэн уусч буй тухай эргэцүүлэн бодоход үзэгчдийг хүргэдэг. Бид хаанаас ирсэн, хэн бэ гэдгийг энд тавигдсан урлагийн бүтээлүүд бидэнд сануулж, бусдад ч гэсэн тэр мэдрэмжийг төрүүлж байдаг юм. Мөн хүн төрөлхтний соёлын ийм баялаг, гайхалтай сайхан хамтын өвийн тухай бидний ойлголтыг улам баяжуулж байна.

The ART in Embassies Program (ART) is a unique blend of art, diplomacy, and culture. Regardless of the medium, style, or subject matter, art transcends barriers of language and provides the means for the program to promote dialogue through the international language of art that leads to mutual respect and understanding between diverse cultures.

The ART in Embassies Program

Modestly conceived in 1964, ART has evolved into a sophisticated program that curates exhibitions, managing and exhibiting more than 3,500 original works of loaned art by U.S. citizens. The work is displayed in the public rooms of some 180 U.S. embassy residences and diplomatic missions worldwide. These exhibitions, with their diverse themes and content, represent one of the most important principles of our democracy: freedom of expression. The art is a great source of pride to the U.S. ambassadors, assisting them in multi-functional outreach to the host country's educational, cultural, business, and diplomatic communities.

Works of art exhibited through the program encompass a variety of media and styles, ranging from eighteenth century colonial portraiture to contemporary multi-media installations. They are obtained through the generosity of lending sources that include U.S. museums, galleries, artists, institutions, corporations, and private collections. In viewing the exhibitions, the thousands of guests who visit U.S. embassy residences each year have the opportunity to learn about our nation – its history, customs, values, and aspirations – by experiencing firsthand the international lines of communication known to us all as art.

The ART in Embassies Program is proud to lead this international effort to present the artistic accomplishments of the people of the United States. We invite you to visit the ART web site, http://aiep.state.gov, which features on-line versions of all exhibitions worldwide.

«Элчин сайдын яамд дахь уран зураг» хөтөлбөр нь урлаг, соёл, улс төр, дипломат харилцааны маш өвөрмөц хослол юм. Урлаг бол арга хэрэгсэл, хэв маяг, сэдэв зэргээс хамааралгүй, үг яриагаар илэрхийлснээс илүүтэйгээр олон улсын урлагийн хэлээр ярилцаж, хоорондоо ялгаатай соёлууд харилцан бие биенээ хүндэтгэж, ойлголцох замыг нээж өгдөг билээ.

«Элчин сайдын яамд дахь уран зураг» хөтөлбөр

1964 онд даруухан эхэлсэн энэхүү хөтөлбөр одоо АНУ-ын иргэдийн зээлдүүлсэн 3500 гаруй урлагийн эх бүтээлээс бүрдэх үзэсгэлэнгүүдийг зохион байгуулж, дэлгэн үзүүлдэг томоохон хөтөлбөр болж өргөжжээ. Эдгээр бүтээлүүдийг дэлхийн 180-аад оронд суугаа АНУ-ын Элчин сайдын яамд, дипломат төлөөлөгчийн газруудын байрны олон нийтэд нээлттэй байдаг хэсэгт дэлгэн үзүүлдэг юм. Сэдэв, агуулгын хувьд ялгаатай эдгээр үзэсгэлэнгүүд манай ардчиллын хамгийн чухал зарчмуудын нэг болох өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөний бэлгэдэл болж байдаг. Урлагийн энэхүү бүтээлүүд нь АНУ-ын элчин сайдуудын хувьд ихээхэн бахархал төрүүлдэг зүйл бөгөөд тухайн суугаа орныхоо боловсрол, соёл, бизнесийн болон дипломат хүрээнийхэнд өөрийн орноо таниулан сурт-чилахад нь тусалдаг юм.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дэлгэн тавигдсан урлагийн бүтээлүүд нь 18-р зууны шилжин суурьшигчдын үеийн хөрөг зургаас эхлээд орчин үеийн малтимедиа бүтээлүүд хүртэл арга хэрэгсэл, хэв маягийн хувьд маш олон янз байдаг. Эдгээр нь АНУ-ын музей, галерей, уран бүтээлчид, байгууллага, корпорацууд болон хувийн цуглуулгаас өгөөмөр сэтгэлээр зээлдүүлсэн бүтээлүүд юм. Жил бүр АНУ-ын Элчин сайдын яамдын байранд зочилж, энэхүү үзэсгэлэнгүүдийг үздэг мянга мянган хүмүүс манай үндэстэн, бидний түүх, зан заншил, үнэт зүйлс, зорилгын тухай улс үндэстэн хоорондын харилцааны хэрэгсэл болох урлагаар дамжуулан олж мэдэх боломжтой байдаг билээ.

«Элчин сайдын яамд дахь уран зураг» хөтөлбөрийнхөн АНУ-ын ард түмний бүтээсэн урлагийн бүтээлүүдийг дэлхий нийтэд танилцуулах энэхүү олон улсын хэмжээний ажлыг манлайлан хэрэгжүүлж байгаадаа бахархалтай байна. Та бүхэн манай http://aiep.state.gov сайтад зочилж, дэлхий даяар тавигдсан үзэсгэлэнгүүдийн онлайн хувилбарыг үзэж сонирхоорой.

Larry ‘Ulaaq’ Ahvakana (born 1946)

“All my life, I was surrounded by my culture and my people, the Inupiaq of northern Alaska. The dances and songs of the Inupiaq tradition are our oral history – the emotional interpretation of our respect for and involvement with the environment of the North Slope of Alaska.

My work incorporates many media and materials and a sense of my cultural design. The interpretation is very personal. I hope the conceptual format gives viewers an idea of the Inupiaq tradition.”

Larry Ahvakana was born in Fairbanks, Alaska, and raised in Barrow and Anchorage. His first introduction to the arts was watching his mother, a very competent skin sewer. He is a graduate of the Rhode Island School of Design in Providence, Rhode Island; the Institute of American Indian Arts in Santa Fe, New Mexico; and the Cooper Union School of Art in New York City.

Established as an outstanding sculptor with a national reputation, Ahvakana has been a professional artist for over thirty years. He is most famous for his Inuit or Inupiaq figures and animals. Sculptured from wood, alabaster, marble, glass, ivory, and cast in bronze or other metals, his images’ pristine, clean-lined form and almost reverent presence capture the spirit of the Inuit/Eskimo. Ahvakana’s works are included in a large number of major museums, numerous corporate collections, and in national and international private collections. He has received several public art commissions.

www.ahvakana.com ■ http://alaskanativearts.org

Ларри «Улаак» Авакана (1946 онд төрсөн)

«Би бүхий л амьдралынхаа турш Хойд Аляскийн Инупиак омгийнхон, тэдний соёл дунд байсан. Инупиакийн уламжлалт дуу бүжиг бол бидний аман түүх бөгөөд Аляскийн хойд бэлийн байгалийг бишрэн шүтэж, түүнтэй холбоотой байдгаа илэрхийлсэн бидний сэтгэлийн илэрхийлэл юм.

Миний бүтээлүүд олон янзын хэрэгсэл, материал болоод миний урлах мэдрэмжийг шингээдэг бөгөөд хүмүүс өөр өөрийнхөөрөө тайлбарладаг. Гэхдээ ерөнхий концепц нь үзэгчдэд Инупиакийн уламжлалын тухай төсөөллийг өгдөг гэдэгт би итгэж байна».

Ларри Авакана Аляска мужийн Фэйрбанкст төрж, Бэрроу, Энкориж хотуудад өсч торнижээ. Арьсаар маш чадварлаг оёж урладаг ээжийгээ ажиглан харж байсан нь түүний хувьд урлагтай танилцсан хамгийн анхны тохиолдол нь байлаа. Тэрээр Провидэнс дахь Роуд Айлэндийн Дизайны сургууль болон Нью Мексико мужийн Санта Фе дахь Америкийн Индиан урлагийн дээд сургууль, мөн Нью-Йорк хотын Күүпэрийн холбооны урлагийн сургуулийг тус тус дүүргэжээ.

Улс даяар алдар нэр нь түгсэн авъяаслаг уран барималч Авакана 30 гаруй жилийн туршлагатай мэргэжлийн уран бүтээлч хүн юм. Инуит буюу Инупиак омгийн холбогдолтой хүн, амьтны дүрс бүхий баримлуудаараа их алдартай. Мод, гипс, гантиг, шил, зааны соёогоор сийлж, хүрэл болон бусад металлуудаар цутгаж урласан түүний баримлууд ямар ч өө сэвгүй, цэвэрхэн хэлбэр, бишрэнгүй гэмээр байдлаараа Инуит, Эскимосчуудын мөн чанарыг илэрхийлдэг. Аваканагийн бүтээлүүд олон тооны томоохон музейнууд, байгууллагын цуглуулга, дотоод, гадаадын хувийн цуглуулгад орсон байдаг. Мөн тэрээр олон нийтийн захиалгаар хэд хэдэн бүтээл урлажээ.

www.ahvakana.com ■ http://alaskanativearts.org сайтуудыг үзнэ үү.

Larry ‘Ulaaq’ Ahvakana
Ларри «Улаак» Авакана

My Tlingit Friend – Frog Clan, 2004

Yellow cedar and fused and slumped bull’s eye glass, 13 x 17 ½ x 5 ½ in.
Courtesy of Alice N. Rogoff, Chair, Alaska Native Arts Foundation, Bethesda, Maryland

Царс, хайлуулжагшаасан шил, 33 x 19,1 x 14 см
Мэрилэнд мужийн Бетезда дахь Аляскийн уугуул иргэдийн урлагийн сангийн
дарга Элис Н. Рогофын дэмжлэгтэйгээр энд толилуулж буй

Susie Qimmiqsaq Bevins (born 1941)

Susie Qimmiqsaq Bevins, Qimmiqsaq being her Inupiat name, is one of the first Native women artists to successfully explore monumental outdoor sculpture. For several years now, she has flourished in the arena of public art commissions in her home state of Alaska.

Qimmiqsaq Bevins' art celebrates Native culture and speaks to the survival of a people. Many of her mixed media works are inspired by Inupiat stories she heard as a child, and are representative of guardian spirits known to the Native people of the North. She has also incorporated other Northwest Native legends into her art. Over the years, she has participated in numerous exhibitions, including such venues as the White House, Washington, D.C., and the Heard Museum, Phoenix, Arizona.

http://clinton4.nara.gov/WH/Tours/Garden_Exhibit6/bevins.html ■ http://alaskanativearts.org

Сьюзи Киммиксак Бэвинз (1941 онд төрсөн)

Сьюзи Киммиксак Бэвинзын Инупиак нэр нь Киммиксак бөгөөд тэрээр байшин доторх монументал уран баримлыг судалж эзэмшсэн анхны уугуул эмэгтэй уран бүтээлчдийн нэг юм. Нилээд хэдэн жилийн турш өөрийн төрсөн нутаг Аляскадаа олон нийтийн захиалгаар бүтээл туурвих талаар амжилттай ажиллаж байна.

Киммиксак Бэвинзын бүтээлүүд уугуул иргэдийн соёлыг хүндэтгэж, эдгээр ард түмний соёл заншлыг хадгалж үлдээхийн төлөө дуугарч байдаг. Холимог хэрэгсэл ашиглан бүтээсэн түүний ажлуудын ихэнх нь хүүхэд байхдаа сонссон Инупиакийн домог түүхээс санаа авсан байдаг бөгөөд тэдгээр нь Хойд нутгийн уугуул хүмүүсийн сахиусан тэнгэрийг төлөөлдөг ажээ. Баруун хойд нутгийн уугуул ард түмнүүдийн үлгэр домгийг ч тэрээр бүтээлдээ багтаасан байдаг. Олон жилийн турш тэрээр Вашингтоны Цагаан ордон, Аризона мужийн Финикс дахь Хөрд музей гэх зэрэг маш олон үзэсгэлэнд бүтээлүүдээ дэлгэн үзүүлж байжээ.

http://clinton4.nara.gov/WH/Tours/Garden_Exhibit6/bevins.html болон ■ http://alaskanativearts.org сайтыг үзнэ үү.

Susie Qimmiqsaq Bevins
Сьюзи Киммиксак Бэвинз

Primal Memories, 2006

Bass wood, antler, aluminum extrusion, and feathers, 13 x 13 x 5 in.
Courtesy of Alice N. Rogoff, Chair, Alaska Native Arts Foundation, Bethesda, Maryland

Занар, бугын эвэр, хөнгөн цагаан, өд, 33 x 33 x 12,7 см
Мэрилэнд мужийн Бетезда дахь Аляскийн Уугуул Урлагийн Сангийн
дарга Элис Н. Рогофын дэмжлэгтэйгээр толилуулж буй

Joseph K. Dixon, lead photographer
Жозеф К. Диксон, тэргүүлэх гэрэл зурагчин

Nina Nethla ,Wife of Nethla, Famous Scout, San Carlos Apache Tribe
Archival pigment copy print from original photograph, 1913. 30 x 38 in.
Эх зургаас татсан архивын хувь, 1913, 76,2 x 96,5 см

All pictures courtesy of the William Hammond Mathers Museum, Indiana University, Bloomington, and the ART in Embassies Program, Washington, D.C.

The prints used in this exhibition have been digitally reproduced either from full-size, high resolution scans of the original prints dating from Joseph K. Dixon's day, or from a modern copy negative, by master printer, Frank H. Day, Washington, D.C.

Блүмингтон дахь Индиана их сургуулийн Уильям Хэммонд Матерс музей болон «Элчин сайдын яамд дахь Уран зураг» хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр толилуулж буй.

Энэхүү үзэсгэлэнд тавигдсан зургууд нь Жозеф К. Диксоны авсан эх зургуудыг бүрэн хэмжээгээр нь өндөр нягтралтай сканераар татаж, дараа нь дижитал аргаар дахин боловруулсан, эсвэл Вашингтоны мастер хэвлэгч Фрэнк Х. Дэйн орчин үеийн негативаас хувилан авсан зургууд юм.

The Bread, Crow Tribe

Archival pigment copy print from original photograph, 1908. 38 x 30 in.

Эх зургаас татсан архивын хувь, 1908
96,5 x 76,2 см

Hoska-Yilth-Na-Ga, Navajo Tribe

Archival pigment copy print from original photograph, 1913. 38 x 30 in.

Эх зургаас татсан архивын хувь, 1913
96,5 x 76,2 см

Ari-Wa-Kis, Young Bull or Captin Jim, Pawnee Tribe
Archival pigment copy print from original photograph, 1913. 50 x 34 in.
Эх зургаас татсан архивын хувь, 1913. 127 x 86,4 см

Bone-Titla, San Carlos Apache Tribe
Archival pigment copy print from original photograph, 1913. 38 x 30 in.
Эх зургаас татсан архивын хувь, 1913. 96,5 x 76,2 см

Hopi Boy Racing Horse, Hopi Tribe

Archival pigment copy print from original photograph, 1913. 34 x 50 in.

Эх зургаас татсан архивын хувь, 1913
86,4 x 127 см

Takes-five, Old Indian Woman, Crow Tribe

Archival pigment copy print from original photograph, 1908. 38 x 30 in.

Эх зургаас татсан архивын хувь, 1908
96,5 x 76,2 см

Bird-All-Over-the-Ground, Crow Tribe
Archival pigment copy print from original photograph, 1908. 30 x 38 in.
Эх зургаас татсан архивын хувь, 1908. 76,2 x 96,5 см

Mother and Papoose, Angela Star and Pretty Owl, Crow Tribe

Archival pigment copy print from original photograph, 1908. 38 x 30 in.

Эх зургаас татсан архивын хувь, 1908
96,5 x 76,2 см

Chief Medicine Crow, 65 years, Crow Tribe

Archival pigment copy print from original photograph, 1908. 38 x 30 in.

Эх зургаас татсан архивын хувь, 1908
96,5 x 76,2 см

Quin-Yiss, Rose Emerson, with Baby – An Indian Madonna, Yuma Tribe
Archival pigment copy print from original photograph, 1913. 38 x 30 in.
Эх зургаас татсан архивын хувь, 1913. 96,5 x 76,2 см

Images of Native Americans: The Wanamaker Collection at Indiana University

It was in 1908 that photographer Joseph K. Dixon set out from his home in Pennsylvania on his first trip to the American West to record images of Native Americans. His idea of the American Indian, before this excursion, was shaped by his culture and his time. Like most European Americans of that era, to Joseph Dixon the American Indians were a "vanishing race" – and his dream was to record them on film before they disappeared.

During his many subsequent photographic trips and related activities over the next dozen years, Dixon came to realize that although their lifestyles and circumstances were changing – as is true for all cultures – Native Americans were not "vanishing." He also experienced the diversity of Indian tribes and customs, and was moved by the reservation conditions under which many lived. The experience changed him: he went from being a recorder of traditional Indian ways to being an advocate for the future of these people he had chosen as his subjects. In 1913 he spearheaded a move to establish an American Indian Memorial and urged a reconciliation between Native groups and the Federal government; in 1915 he lobbied for American citizenship for the original inhabitants of the nation; and after World War I he publicized the sacrifice of Native American soldiers on the battlefields of Europe.

Many European Americans have traveled a similar path of coming to know and respect Native Americans and their cultures, but what makes Dixon's contribution important is that he recorded his journey of discovery with his camera. The 8,000 images in the Wanamaker Collection of Native American Photographs depict Dixon's changing perceptions of Native Americans and his appreciation of the diversity of Indian cultures and the dignity of individual people. The Wanamaker Collection is housed at the Mathers Museum of World Cultures, at Indiana University in Bloomington. Rodman Wanamaker and his family, philanthropists and proprietors of the famous Wanamaker's department store in Philadelphia, Pennsylvania, sponsored Dixon's work.

Information provided by the Mathers Museum of World Cultures, at Indiana University in Bloomington, www.indiana.edu/~mathers.

Уугуул Америкчуудын дүр төрх: Индиана их сургууль дахь Ванамэйкерийн цуглуулга

1908 онд гэрэл зурагчин Жозеф К. Диксон уугуул Америкчуудын дүр төрхийг хальсандаа буулгахаар Америкийн баруун хязгаарыг зорин Пенсильваниа дахь гэрээсээ гарчээ. Энэхүү аялалын өмнө Америкийн индианчуудын тухай түүний ойлголт өөрийнх нь соёл болон цаг үеэр тодорхойлогдож байв. Европоос гаралтай ихэнх Америкчуудын нэгэн адил түүний хувьд Америкийн индианчууд бол «мөхөж буй үндэстэн» байсан бөгөөд бүрмөсөн алга болохоос нь өмнө тэдний дүр төрхийг хальсанд буулгах нь түүний мөрөөдөл байлаа.

Эхний аялалаас хойшхи 10 гаруй жилийн хугацаанд тэрээр гэрэл зураг авахаар юмуу, эсвэл өөр ажлаар хэд хэдэн удаа тийшээ очихдоо хэдийгээр бусад бүх соёлуудын нэгэн адил амьдралын хэв маяг, бусад нөхцөл байдал нь өөрчлөгдөж байгаа ч уугуул Америкчууд «мөхөж буй» биш юм гэдгийг Диксон ойлгожээ. Тэрээр Индиан омгууд болон тэдний зан заншил өөр хоорондоо ялгаатай болохыг харж, тэдний амьдарч буй нутаг орон, амьдралын нөхцөлд сэтгэл зовниж байв. Энэ аялалууд түүнийг ихээхэн өөрчилжээ. Индианчуудын уламжлалыг зүгээр л хальсанд буулгадаг нэгэн байсан тэрээр уран бүтээлийнхээ сэдэв болгон сонгож авсан тэдгээр хүмүүсийнхээ ирээдүйн төлөө тэмцэгч болж хувирсан байна. 1913 онд Диксон Америкийн Индианчуудад зориулсан хөшөө дурсгал босгох ажлыг манлайлж, уугуул Америкчууд болон Холбооны Засгийн газрыг зөвшилцөлд уриалж байлаа. 1915 онд тэрээр нутгийн уугуул иргэдэд Америкийн иргэншил олгох асуудлыг дэмжүүлэхээр лобби хийжээ. Дэлхийн 1-р дайны дараа тэрээр Европт тулалдааны талбарт амь үрэгдсэн уугуул Америк гаралтай цэргүүдийн дурсгалд олон нийтийн анхаарлыг хандуулж чадсан юм.

Европоос гаралтай Америкчуудын олонх нь уугуул Америкчууд болон тэдний соёлыг таньж мэдэх, хүндэтгэж хандах хүртэлх ижил төстэй замыг туулсан хэдий ч Диксоны оруулсан хувь нэмэр юугаараа чухал вэ гэхээр тэр олж мэдсэн зүйлсээ гэрэл зургийн хальсанд буулган авч чадсанд байгаа юм. Ванамэйкерийн цуглуулганд хадгалагдаж буй уугуул Америкчуудын 8000 гаруй гэрэл зургуудаас тэдний тухай Диксоны ойлголт хэрхэн өөрчлөгдсөнийг, мөн Индианчуудын соёл хоорондоо хичнээн ялгаатай болохыг, хувь хүмүүсийн сүр жавхааг харж болно. Энэхүү цуглуулга нь Блүмингтон дахь Индиана их сургуулийн дэргэдэх Дэлхийн соёлын Матерс музейд хадгалагдаж байдаг. Пенсильваниа мужийн Филадельфиа дахь Ванамэйкерийн их дэлгүүрийг эзэмшигч Родман Ванамэйкер болон түүний гэр бүлийнхэн Диксоны ажлыг ивээн тэтгэж байсан юм.

Мэдээллийг Блүмингтон дахь Индиана их сургуулийн дэргэдэх Дэлхийн соёлын Матерс музейгээс авлаа. www.indiana.edu/~mathers.

Rose Keith (born 1919)

The best-known native textile art in North America is the weaving of Navajo Indian blankets and rugs. These impressive rugs are still made in a technique that was traditional in Mexico and the southwestern United States long before the arrival of Europeans: the weaver kneels before a vertical wooden-frame loom and uses a shuttle to weave colored threads together into large-scale geometric designs. Originally Navajo and other Southwest Indian blankets were made of hand-spun cotton thread, but after the Spanish brought domestic sheep to the region the people primarily switched to wool.

http://www.native-languages.org/rugs.htm

Роуз Кийт (1919 онд төрсөн)

Хойд Америкт алдартай сүлжмэл урлагийн гол төлөөлөл бол Навахо Индианчуудын нэхмэл хөнжил, ширдэгнүүд юм. Эдгээр гайхалтай ширдгийг Европчууд Америкт суурьшихаас хамаагүй өмнө Мексик болон Америкийн баруун өмнөд нутагт уламжлал болоод байсан арга техникээр урлажээ. Нэхэгч босоо модон рамтай нэхмэлийн машины өмнө сөхрөн суугаад, өнгө өнгийн утсыг модоор хийсэн сүлжигч хэрэгсэл ашиглан сүлжиж, том том геометрийн дүрс гаргаж нэхдэг байв. Навахочууд болон Баруун өмнөд нутгийн Индианчууд эхлээд гараар ээрсэн хөвөн даавуун утас ашиглан хөнжил нэхдэг байсан бол Испаничууд энэ бүс нутагт гэршүүлсэн хонь авчирснаас хойш ноос ашигладаг болжээ.

http://www.native-languages.org/rugs.htm

Navajo traditional woven rug with raised outline, mid 20th century
Wool, 49 ¼ x 28 in. Courtesy of a Private Collection

Навахо уламжлалт аргаар хээг товойлгож
нэхсэн ширдэг, 20-р зууны дунд үе
Ноос, 125,1 x 71,1 см. Хувийн цуглуулгаас

Rose Keith
Роуз Кийт



Acknowledgments

Washington

Anne Johnson, Director,
ART in Embassies Program
Sarah Tanguy, Curator
Jamie Arbolino, Registrar
Marcia Mayo, Publications Editor
Sally Mansfield, Publications Project Coordinator
Amanda Brooks, Imaging Specialist

Ulaanbaatar

Harold Zappia, Management Officer
Thomas Galloway, Facilities Maintenance Officer
Danielle Wood, General Services Officer
Dale Lawton, General Services Officer
Ch. Tuul, Translator
P. Tina, Information Assistant
B. Toshka, Photographer

Vienna

Nathalie Mayer, Graphic Designer

Талархал

Вашингтон

Энн Жонсон, «ЭСЯамд дахь уран зураг» хөтөлбөрийн захирал
Сара Тангий, музейн эрхлэгч
Жэйми Арболино, бүртгэгч
Марсиа Майо, хэвлэлийн редактор
Салли Мэнсфилд, хэвлэлийн төслийн зохицуулагч
Аманда Брүүкс, имижийн мэргэжилтэн

Улаанбаатар

Хэролд Запиа, захиргааны хэлтсийн дарга
Томас Галовэй, барилга засварын хэсгийн дарга
Даниэль Вүүд, аж ахуйн хэлтсийн дарга
Дэйл Лоутн, аж ахуйн хэлтсийн дарга
Ч. Туул, орчуулагч
П. Тина, мэдээллийн туслах ажилтан
Б. Тошка, гэрэл зурагчин

Вена

Натали Мэйер, график дизайнер

Designed at the Regional Program Office, Vienna

Published by the ART in Embassies Program
U.S. Department of State, Washington, D.C.
May 2007